

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН 2012 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Илтгэгч нь: Ерөнхий шүүгч Ц.Зориг

Эрхэм шүүгч, ажилтнуудаа!

Өнгөрч буй 2012 онд бид Шүүхийн тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай, Шүүхийн захиргааны тухай, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай зэрэг шүүхийн багц хуулиудыг Улсын Их Хурлаар батлуулах, тэдгээрт заасан дүрэм, журмын төслийг боловсруулах, батлуулах, шинээр батлагдсан хуулиудын хэрэгжилтийн бэлтгэл ажил, зохион байгуулалтыг хангах, шүүн таслах ажиллагааны чанар, үр дүнг дээшлүүлэх зорилгоор бүсчилсэн уулзалт, ярилцлага, зөвлөгөөнийг зохион байгуулах, “Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөрийг шүүхэд хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх үндсэн чиглэл”-н дагуу тодорхой зарим арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлэх зэрэг зорилтыг тус тус дэвшүүлэн ажилласан бөгөөд энэ чиглэлүүдэд зарим тодорхой үр дүн, ахиц гарч үүнд Та бүхний оролцоо идэвхи зүтгэл, санал санаачлага чухал байсныг цохон тэмдэглэе.

2012 он ажил хөдөлмөр өрнүүн жил байлаа.

Та бидний хөдөлмөр зүтгэлийг төр өндрөөр үнэлж, Сар шинийн баяр, Үндэсний их баяр наадам, Их Монгол Улс байгуулагдсаны 806 жил, Ардын хувьсгалын 91 жил, Их эзэн Чингис хааны хааны мэндэлсний 850 жилийн ойг тус тус тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Улсын Дээд шүүхийн шүүгч асан, Улсын Дээд шүүхийн ахмадын зөвлөлийн гишүүн Д.Пунцаг “Монгол Улсын Гавъяат хуульч” цолоор, шүүгч Т.Уранцэцэг “Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон”-гоор, Иргэний хэргийн танхимын тэргүүн Б.Ундрах “Алтан гадас” одонгоор, Дотоод ажил, зохион байгуулалт, хяналтын албаны дарга Ж.Наранпүрэв, бичиг хүргэгч А.Пүрэвдулам, жолооч М.Рэнцэндорж, үйлчлэгч Ц.Пагма, үйлчлэгч Ц.Цэцэгсүрэн нар “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар тус тус шагнагдлаа.

Мөн Улсын Дээд шүүх байгуулагдсаны 85 жилийн ойг тохиолдуулан шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүхийн өөрчлөлт, шинэчлэл, төлөвшилтөд зохих хувь нэмэр оруулан ажиллаж байсныг нь үнэлж Улсын Дээд шүүхийн ахмадын зөвлөлийн гишүүн Э.Бадам, Д.Баттөр, Л.Бямбаа, М.Дамирансүрэн, Д.Данзандорж, Д.Цэрэнбалтав, Ө.Пүрэв нарыг Улсын Дээд шүүхийн “Хүндэт тэмдэг”-ээр, Т.Очиржав, Р.Ишцог, Ё.Цэрэндэжид, С.Баасансүх, Ч.Должин нарыг Шүүхийн Ерөнхий зөвлөлийн “Хүндэт тэмдэг”-ээр тус тус шагналаа.

Түүнчлэн Монгол Улсад шүүх байгуулагдсаны 101 жилийн ойг тохиолдуулан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ хараат бус байж, гагцхүү хуульд захирагдан ажиллаж, аливаа хэрэг, маргааныг хуульд нийцүүлэн шийдвэрлэж, шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, шүүхийн өөрчлөлт, шинэчлэлтэд зохих хувь нэмэрээ оруулж байгаа болон шүүхийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэх, шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхэд хэрэг, маргааны судалгаа хийж, шүүгчид танилцуулах, шүүх хуралдааны бэлтгэл ажлыг хангах, техник зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, төрийн буухиаг түмний тусад хүргэх, эрхэлсэн ажилдаа хариуцлагатай, сонор сэрэмжтэй ажиллаж байгааг нь үнэлж Ховд аймгийн шүүхийн ахмад ажилтан Д.Алимаа Улсын Дээд шүүхийн “Хүндэт тэмдэг”-ээр, Булган аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч, Г.Мягмарсүрэн, Дархан-Уул аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч Л.Оюунцэцэг, Хэнтий аймаг дахь сум дундын 1-р шүүхийн шүүгчийн туслах П.Нансалмаа, Сүхбаатар аймгийн шүүхийн нярав М.Ганхуяг, Хэнтий аймгийн шүүхийн бичиг хүргэгч С.Эрцэрэг, Дундговь аймгийн шүүхийн жижүүр С.Цолмон нарын 6 хүн Ерөнхий шүүгчийн захирамжаар Улсын Дээд шүүхийн “Жуух бичиг”-ээр тус тус шагнагджээ.

2012 онд шүүгч С.Нямжавыг Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүний, Д.Эрдэнэбалсүрэн, Х.Батсүрэн, Х.Сонинбаяр нарыг Улсын Дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсон Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг гарлаа.

Улсын Дээд шүүхээс 2012 онд дараах бүтээлийг эрхлэн хэвлүүллээ. Тухайлбал,

- Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар;
- “Захиргааны эрх зүй” сургалтын гарын авлага-4;
- Иргэний процессын толь бичгийн тайлбар;
- “Шүүхийн 2011 оны ажлын тайлан” зэргийг хэвлүүлж, олон нийтийн хүртээл болголоо.

2012 оны 2 дугаар сарын 8, 6 дугаар сарын 8-ны өдрүүдэд Шүүгчдийн зөвлөл хуралдлаа. Уг хуралдаанаас **Шүүхийн Ерөнхий зөвлөлийн гишүүнээр:**

- Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн С.Нямжав;
- Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн Б.Ундрах;
- Сүхбаатар аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч А.Энхбаатар;
- Дорноговь аймаг дахь сум дундын 1-р шүүхийн Ерөнхий шүүгч Х.Ганболд нарыг,

Шүүхийн Мэргэшлийн хорооны дарга, гишүүнээр:

- Улсын Дээд шүүхийн шүүгч А.Доржготов;
- Улсын Дээд шүүхийн шүүгч Л.Атарцэцэг;
- Нийслэлийн шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн П.Золзаяа;
- Дархан-Уул аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч Л.Амарсанаа;
- Хэнтий аймгийн шүүхийн шүүгч Б.Дэнсмаа нарыг,

Шүүхийн сахилгын хорооны дарга, гишүүнээр:

- Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн О.Зандраа;
- Улсын Дээд шүүхийн шүүгч Ц.Сумъяа;
- Сэлэнгэ аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч Б.Батзориг;
- Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн Ерөнхий шүүгч Х.Батсүрэн;
- Нийслэлийн шүүхийн шүүгч Г.Алтанчимэг;
- Баян-Өлгий аймгийн шүүхийн шүүгч С.Еркеш нарыг тус тус сонгов.

Мөн хуралдаанаар Шүүхийн мэргэшлийн болон Сахилгын хороо, Шүүгчдийн холбооны **2011** онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг хэлэлцлээ.

Улсын Дээд шүүхийн эрүү, иргэн, захиргааны хэргийн танхимын шүүн таслах ажиллагааны дүн мэдээ болон Танхимууд, Тамгын газрын тайлан гарлаа.

Ингээд Улсын Дээд шүүхийн **2012** оны **Нэгдсэн тайланг** товч танилцуулъя.


Нэг. Шүүн таслах ажиллагааны талаар

Нийт шүүгчдийн хуралдаан:


2012 онд нийт шүүгчдийн хуралдааныг **5** удаа зарлан, нийт **5** өдөр хуралдуулж, бүгд **12** асуудал хэлэлцэж, **12** тогтоол гаргасны дотор эрүүгийн хэрэг **10**, иргэний хэрэг **1**, бусад асуудал **1**-ийг тус тус хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

Өнгөрсөн **2011** онтой харьцуулахад Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлын тоо **1**-ээр, эрүүгийн хэрэг **7**-оор нэмэгдэж, бусад асуудал **5**-аар буурсан байна.

Нийт шүүгчдийн хуралдааны үзүүлэлт




Нийт шүүгчдийн хуралдааны 2011-2012 оны харьцуулалт



1. Эрүүгийн хэргийн танхим:

Эрүүгийн хэргийн танхим өмнөх оны үлдэгдэл 13 хэрэг дээр нэмж хяналтын журмаар эрүүгийн 680, цагаатгалын 356, нийт 1049 хэрэг хүлээн авч, 502 эрүүгийн, 355 цагаатгалын буюу нийт 857 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, 71 хэргийг хянан буцааж, 81 хэргийг Ерөнхий шүүгчийн ажлын албанд шилжүүлж, Ерөнхий шүүгчийн дүгнэлтээр 1 хэрэг, цаазаар авах ялтай 9 хэрэг, нийт 10 хэрэг Нийт шүүгчдийн хуралдаанаар хянагдаж, одоо 40 хэргийн үлдэгдэлтэй байна.

Нийт хүлээн авсан 1049 хэргээс



Эрүүгийн хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдаан нийт 55 өдөр хуралдаж, **өдөрт** дунджаар 15,5 хэрэг хэлэлцжээ.

Хяналтын журмаар хэлэлцэгдсэн эрүүгийн 857 хэргийн 37.6 хувь буюу 322 хэргийн тогтоол, магадлалыг хэвээр үлдээж, гомдол, эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож, 10.3 хувь буюу 88 хэргийн тогтоол, магадлалд өөрчлөлт оруулж, 52.1 хувь буюу 447 хэргийн тогтоол, магадлалыг хүчингүй болгосон байна.


Өөрчлөлт оруулсан 88 тогтоол, магадлалын 37.5 хувь буюу 33 нь Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн, 31.8 хувь буюу 28 нь хуулийг жинхэнэ агуулгаас зөрүүтэй буруу ойлгож

хэрэглэсэн, **8** хувь буюу **7** нь шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, **22.7** хувь буюу **20** шийтгэх тогтоол, магадлалд бусад өөрчлөлт оруулжээ.

Хүчингүй болгосон **447** тогтоол, магадлалтай хэргээс **54** хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр **прокурорт**, **21** хэргийг **шүүхээр дахин хэлэлцүүлэхээр** буцааж, **359** хэргийг **хэрэгсэхгүй** болгож, **10** хэргийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, магадлалыг хүчингүй болгосон, шийтгэх тогтоол, магадлалын зарим заалтыг хүчингүй болгосон **3** хэрэг байна.

Хяналтын журмаар шүүгч Б.Бат-Эрдэнэ **239**, Т.Уранцэцэг **213**, Танхимын тэргүүн С.Нямжав **210**, шүүгч Д.Эрдэнэбалсүрэн **210**, Х.Батсүрэн **49**, С.Батдэлгэр **7**, Ерөнхий шүүгчийн ажлын алба **81** эрүүгийн хэрэг тус тус **хүлээн** авчээ.

Шүүгч тус бүрийн болон Ерөнхий шүүгчийн ажлын албаны хүлээн авсан хэрэг




Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн С.Нямжав **808**, шүүгч Д.Эрдэнэбалсүрэн **684**, Б.Бат-Эрдэнэ **670**, Т.Уранцэцэг **594**, Х.Батсүрэн **238**, С.Батдэлгэр **21** удаа тус тус **оролцож**, танхим нийт **95** албан бичиг, **121** өргөдөл, гомдол хүлээн авснаас;

Танхимын тэргүүн С.Нямжав **616**, шүүгч Б.Бат-Эрдэнэ **79**, Д.Эрдэнэбалсүрэн **77**, Т.Уранцэцэг **57**, С.Батдэлгэр **7** (О.Зандраа **13**, Ц.Сумъяа **4**, Ц.Амарсайхан **4**) хэргийн шүүх хуралдааныг тус тус **даргалж**;

Шүүгч Б.Бат-Эрдэнэ **211**, Т.Уранцэцэг **204**, Д.Эрдэнэбалсүрэн **199**, Танхимын тэргүүн С.Нямжав **191**, Х.Батсүрэн **45**, С.Батдэлгэр **7** хэрэг тус тус **илтгэж**;

Танхимын тэргүүн С.Нямжав **77** албан бичиг, **79** өргөдөл гомдол, шүүгч С.Батдэлгэр **9** албан бичиг, **19** өргөдөл гомдол, Х.Батсүрэн **4** албан бичиг, **2** өргөдөл гомдол, Б.Бат-Эрдэнэ **3** албан бичиг, **1** өргөдөл гомдол, Д.Эрдэнэбалсүрэн **2** албан бичиг, **7** өргөдөл гомдол, Т.Уранцэцэг **9** өргөдөл гомдлыг тус тус хянан шийдвэрлэж, цагаатгалын ажилтай холбоотой **4** өргөдлийн үлдэгдэлтэй байна.



Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн цагаатгалын **355** хэргээс **385** хүнд холбогдох **354** хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгон тэднийг цагаатгаж, **1** хэргийн тогтоолд овог, нэрийг нь зөвтгөсөн өөрчлөлт оруулжээ.

Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн **857** хэргийн **52,1** хувь буюу **447** нь ялтан, өмгөөлөгч, хохирогч, тэдний хууль ёсны төлөөлөгчийн

гомдлоор, 4,7 хувь буюу 40 нь улсын яллагчийн эсэргүүцлээр, 43,2 хувь буюу 370 нь прокурорын дүгнэлтээр хэлэлцэгджээ.

Тайлангийн хугацаанд шүүгч Б.Бат-Эрдэнэ 28, Танхимын тэргүүн С.Нямжав 19, шүүгч Д.Эрдэнэбалсүрэн 11, Т.Уранцэцэг 9, Х.Батсүрэн 4 хэргийг тус тус хянан, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зохих заалтуудыг зөрчсөн эсвэл гомдол гаргах хугацаа хэтэрсэн гэсэн үндэслэлээр, мөн Ерөнхий шүүгчийн ажлын алба 79 хэргийг хянан зохих хариуг өгөх байдлаар тус тус буцаасан байна.

Хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанд:

Шүүгч Д.Эрдэнэбалсүрэн 168, Б.Бат-Эрдэнэ 70, Т.Уранцэцэг 42, Х.Батсүрэн 28, Танхимын тэргүүн С.Нямжав 27 удаа тус тус оролцжээ.

Харин хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанд:

Шүүгч Х.Батсүрэн 29, Д.Эрдэнэбалсүрэн 24, Т.Уранцэцэг 13, Танхимын тэргүүн С.Нямжав 9 удаа оролцсоноос 5 удаа даргалж тус тус оролцсон байна.


Тайлангийн хугацаанд танхимын тэргүүний захирамж 181 гарснаас Танхимын тэргүүний “шүүхийн харьяалал тогтоох тухай” захирамж 72, бусад захирамж 109, мөн шүүхийн тогтоол 15 гарсан байна.

2. Иргэний хэргийн танхим:

Иргэний хэргийн танхим өмнөх оны үлдэгдэл 43 хэрэг дээр нэмж, хяналтын журмаар иргэний 769, Ерөнхий шүүгчид гомдол гаргасан 143, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг хянуулах тухай хүсэлтээр 26, нийт 981 хэрэг хүлээн авчээ.

Тайлангийн хугацаанд 753 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, 23 хэргийг хяналтын журмаар хянан хэлэлцэхээс татгалзаж, иргэний хэргийн харьяалал тогтоолгохоор ирүүлсэн 5 хэргийн харьяаллыг тогтоож, 24 хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг хянуулах тухай хүсэлтээр хянан хэлэлцэж, 149 хэргийг Ерөнхий шүүгчийн ажлын албанд шилжүүлж, Ерөнхий шүүгчийн дүгнэлтээр 1 хэрэг Нийт шүүгчдийн хуралдаанаар хянан хэлэлцэж, одоо 26 хэргийн үлдэгдэлтэй байна.

Нийт хүлээн авсан 981 хэргээс



Иргэний хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдаан нийт 75 өдөр хуралдаж, өдөрт дунджаар 10.3 хэрэг хянан хэлэлцэж, нийт 776 /1 хэргийг захиргааны хэргийн танхим шийдвэрлэсэн/ хэрэг хянан шийдвэрлэжээ.

Хяналтын журмаар хянан хэлэлцэгдсэн иргэний 753 хэргийн 60.2 хувь буюу 454 хэргийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хэрэгсэхгүй болгож, 12.2 хувь буюу 92

хэргийн шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж, **8.6** хувь буюу **65** хэргийн шийдвэрийг хэвээр үлдээж, магадлалыг хүчингүй болгож, **18.8** хувь буюу **142** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгосон байна.


Өөрчлөлт оруулсан **92** шийдвэр, магадлалын **64** хувь буюу **59** нь хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хууль хэрэглэсэн, хууль буруу тайлбарлаж хэрэглэсэн, **35** хувь буюу **33** нь шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн үндэслэлээр шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулжээ.

Хүчингүй болгосон **142** шийдвэр, магадлалтай хэргээс **84.5** хувь буюу **120** хэргийг шүүхээр дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж, **15.5** хувь буюу **22** хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон байна.

Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг буюу хэргийг хэрэгсэхгүй болгосон, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан **142** хэргийн **65.5** хувь буюу **93** нь шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, **34.5** хувь буюу **49** нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн байна.

Хяналтын журмаар шүүгч **А.Доржготов 211, Д.Тунгалаг 205, Ц.Амарсайхан 194,** Танхимын тэргүүн **Б.Ундрах 97, шүүгч Л.Бямбаа 78, Х.Сонинбаяр 36** хэрэг тус тус хүлээн авчээ.

Шүүгч тус бүрийн хүлээн авсан хэрэг




Хяналтын шатны Иргэний хэргийн шүүх хуралдаанд шүүгч **А.Доржготов 656, Д.Тунгалаг 638, Ц.Амарсайхан 632,** Иргэний танхимын тэргүүн **Б.Ундрах 616, шүүгч Л.Бямбаа 116, Х.Сонинбаяр 108** удаа тус тус оролцож, танхим нийт **104** албан бичиг, **76** өргөдөл, гомдол хүлээн авснаас;

Танхимын тэргүүн **Б.Ундрах 525, шүүгч Ц.Амарсайхан 100, А.Доржготов 84, Д.Тунгалаг 44, Л.Бямбаа 10, Х.Сонинбаяр 5** хуралдааныг тус тус даргалж,

Шүүгч **А.Доржготов 201, Д.Тунгалаг 194, Ц.Амарсайхан 185,** Танхимын тэргүүн **Б.Ундрах 91, шүүгч Л.Бямбаа 75, Х.Сонинбаяр 30** хэрэг тус тус илтгэж;

Танхимын тэргүүн **Б.Ундрах 90** албан бичиг, **45** өргөдөл гомдол, шүүгч **А.Доржготов 9** албан бичиг, **2** өргөдөл гомдол, **Д.Тунгалаг 4** албан бичиг, **2** өргөдөл гомдол, **Ц.Амарсайхан 1** албан бичиг, **1** өргөдөл гомдол, **Л.Бямбаа 1** өргөдөл тус тус хянан шийдвэрлэж, **25** өргөдөл гомдлыг шийдвэрлүүлэхээр Тамгын газар болон бусад танхимд шилжүүлжээ.

Иргэний хэргийн танхимын шүүгчдийн 2012 оны бүтэн жилийн ажлын ачаалал



Нийт шүүгчдийн хуралдаанаар иргэний **1** хэргийг Ерөнхий шүүгчийн дүгнэлтээр хянан хэлэлцэж, шийдвэрлэжээ.

Хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн **324** нэхэмжлэгчийн, **416** хариуцагчийн, **12** гуравдагч этгээдийн гомдлоор, **1** хэрэг прокурорын эсэргүүцлээр хянан хэлэлцэгджээ.

Хяналтын шатны **эрүүгийн** хэргийн шүүх хуралдаанд:

Шүүгч **Д.Тунгалаг 133**, **Ц.Амарсайхан 97** удаа оролцсоноос **4** удаа даргалж, **Х.Сонинбаяр 98**, **А.Доржготов 91**, Танхимын тэргүүн **Б.Ундрах 20** удаа тус тус оролцжээ.

Харин **захиргааны** хэргийн шүүх хуралдаанд:

Шүүгч **Д.Тунгалаг 44**, **Ц.Амарсайхан 35**, **А.Доржготов 33** удаа оролцсоноос **1** хэргийг илтгэж, Танхимын тэргүүн **Б.Ундрах 20**, шүүгч **Х.Сонинбаяр 16** удаа тус тус оролцжээ.

Иргэний хэргийн танхим 2012 онд Улс төрийн намын бүртгэлийн талаар дараах ажлыг хийжээ. Үүнд:

Шинээр:

1. “Эх орончдын нэгдсэн нам”;
2. “Монгол Консерватив нам”-ыг тус тус улсын бүртгэлд бүртгэж,

Намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хүссэн:

1. “Иргэний Зориг нам”;
2. “Бүгд найрамдах нам”;
3. “Монголын уламжлалын нэгдсэн нам”;
4. “Иргэний Хөдөлгөөний нам”;
5. “Хамуг Монголын Хөдөлмөрийн нам”;
6. “Монголын Либерал нам”;
7. “Монголын Ногоон нам”-ын хүсэлтүүдийг хүлээн авч зохих бүртгэлд бүртгэжээ.


Тайлангийн хугацаанд танхимын тэргүүний болон шүүгчийн захирамж **997**-г гаргаснаас шүүгчийн “Гомдлыг хүлээж авахаас татгалзах тухай” **14**, “Гомдол гаргаагүйд тооцох тухай” **5**, “Гомдол хэлэлцүүлэхээс татгалзах тухай” **3**, “Улсын тэмдэгтийн хураамж буцааж олгох тухай” **187** захирамж, Танхимын тэргүүний “Шүүх бүрэлдэхүүн томилох тухай” **779**, “харъяалал тогтоох” **5**, “хэргийн хугацаа сунгах тухай” **4** захирамж тус тус гарчээ.

3.Захиргааны хэргийн танхим:

Захиргааны хэргийн танхим өмнөх оны үлдэгдэл **9** хэрэг дээр нэмж хяналтын журмаар **222**, Ерөнхий шүүгчид гомдол гаргасан **40**, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг хянуулах тухай хүсэлтээр **10**, нийт **281** хэрэг хүлээн авчээ.

Тайлангийн хугацаанд **220** хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, **6** хэргийг хяналтын журмаар хянан хэлэлцэхээс татгалзаж, **41** хэргийг Ерөнхий шүүгчийн ажлын албанд шилжүүлж, одоо **14** хэргийн үлдэгдэлтэй байна.

Хяналтын журмаар нийт хүлээн авсан 281 хэргээс



Захиргааны хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдаан нийт **33** өдөр хуралдаж, **өдөрт** дунджаар **6.6** хэрэг хэлэлцэн, нийт **220** хэргийг хянан шийдвэрлэжээ.

Захиргааны хэргийн танхимд хяналтын шатны журмаар ирүүлсэн **220** хэргээс нэг шүүгчид **44** хэрэг тус тус ногдож байна.

Хяналтын журмаар хэлэлцэгдсэн захиргааны **212** хэргийн **64.1** хувь буюу **136** хэргийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхиж, **11.7** хувь буюу **25** хэргийн шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж, **24** хувь буюу **51** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгосон байна.


Өөрчлөлт оруулсан **25** шийдвэр, магадлалын **80** хувь буюу **20** нь хууль буруу хэрэглэсэн, **20** хувь буюу **5** нь шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй байна.

Хүчингүй болгосон **51** шийдвэр, магадлалтай хэргээс **14** хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж, **7** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, **30** хэргийн магадлалыг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээсэн байна.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай **8** хэргийн **4** хэргийн хүсэлтийг ханаагүй, **4** хэргийн хүсэлтийг хангаж шийдвэрлэжээ.

Хяналтын журмаар шүүгч П.Цэцгээ **54**, Ц.Сумъяа **53**, Ч.Тунгалаг **53**, Л.Атарцэцэг **51**, Танхимын тэргүүн О.Зандраа **23** хэрэг тус тус хүлээн авчээ.

Шүүгч тус бүрийн хүлээн авсан хэрэг




Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн О.Зандраа **180**, шүүгч Л.Атарцэцэг **149**, Ч.Тунгалаг **144**, Ц.Сумъяа **141**, П.Цэцгээ **140** удаа тус тус **оролцож**, танхим нийт **43** албан бичиг, **1** өргөдөл, гомдол хүлээн авснаас;

Танхимын тэргүүн О.Зандраа **158**, Ц.Сумъяа **21**, П.Цэцгээ **14** Л.Атарцэцэг **11**, Ч.Тунгалаг **11** хэргийн шүүх хуралдааныг тус тус **даргалж**;

Шүүгч Ч.Тунгалаг **52**, П.Цэцгээ **52**, Ц.Сумъяа **48**, Л.Атарцэцэг **46**, Танхимын тэргүүн О.Зандраа **22** хэрэг тус тус **илтгэж**;

Шүүгч Ц.Сумъяа **10** албан бичиг, Ч.Тунгалаг **10** албан бичиг, Танхимын тэргүүн О.Зандраа **8** албан бичиг, шүүгч Л.Атарцэцэг **7** албан бичиг, **1** өргөдөл, гомдол, П.Цэцгээ **7** албан бичгийг тус тус шийдвэрлэж, одоо **1** албан бичгийн үлдэгдэлтэй байна.

Захиргааны хэргийн танхимын шүүгчдийн 2012 оны ажлын ачаалал



Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн **55.9** хувь буюу **131** нь нэхэмжлэгчийн, **26.9** хувь буюу **63** нь хариуцагчийн, **17.0** хувь буюу **40** нь гуравдагч этгээдийн гомдлоор хянан хэлэлцэгджээ.

Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд:

Шүүгч Ц.Сумъяа **286** удаа оролцсоноос **4** удаа даргалж, П.Цэцгээ **189**, Ч.Тунгалаг **167**, Л.Атарцэцэг **89** удаа тус тус оролцож, Танхимын тэргүүн О.Зандраа **63** удаа оролцсоноос **13** удаа даргалжээ.

Харин хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанд:

Шүүгч Ц.Сумъяа **233**, Танхимын тэргүүн О.Зандраа **164** удаа оролцсоноос **8** удаа даргалж, шүүгч Л.Атарцэцэг **146**, П.Цэцгээ **115**, Ч.Тунгалаг **113** удаа тус тус оролцжээ.

Тайлангийн хугацаанд танхимын тэргүүний болон шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол **394** гаргаснаас “гомдол хэлэлцүүлэхээс татгалзах тухай” шүүгчийн захирамж **2**, “гомдол гаргаагүйд тооцох тухай” шүүгчийн захирамж **2**, “шүүх хуралдааныг хойшлуулах тухай” шүүхийн тогтоол **60**, Танхимын тэргүүний “шүүх бүрэлдэхүүн томилох тухай” захирамж **269**, “улсын тэмдэгтийн хураамж буцаах тухай” захирамж **43**, “шинээр илэрсэн нөхцөл байдлын хүсэлтийг шийдвэрлэх тухай” шүүхийн тогтоол **8**, бусад захирамж **10** байна.

Хоёр. Мэргэжлийн удирдлагаар хангах ажиллагааны талаар

Тайлангийн хугацаанд эрүү, иргэн, захиргааны хэргийн танхимын тэргүүнүүд болон шүүгчид **Баянхонгор, Дархан-Уул, Завхан, Сүхбаатар, Ховд** аймгийн шүүхийн ажилтай танилцах, мэргэжлийн удирдлагаар ханган, холбогдох сургалтыг газар дээр нь зохион байгуулж ажиллалаа.

Нийт шүүгчдийн хуралдаанаар дээрхи шүүхүүдийн ажилтай танилцан, мэргэжлийн удирдлагаар хангасан тухай асуудлыг хэлэлцэн **тэмдэглэл** гарган холбогдох шүүхүүдэд нь хүргүүлжээ.

Гурав. Тамгын газрын ажлын талаар

Тамгын газар нь Шүүхийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гарсан дүрэм, журам, заавар, Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх, нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хугацаанд нь хийж гүйцэтгэх талаар анхааран ажиллаж иржээ.

Авлигын эсрэг хууль, “Албан тушаалтны хувийн ашиг сонирхолын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-д заасны дагуу шүүгч, захиргааны албан хаагчдаас “Албан тушаалтны хувийн ашиг сонирхолын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг”-ийг 2011 оны байдлаар шинэчлэгдсэн маягтын дахин гаргуулан авч, 17 шүүгчийн материалыг “Авлигатай тэмцэх газар”-т хүргүүлж, захиргааны албан хаагч 1 хүний материалыг Шүүхийн Ерөнхий зөвлөлд, 43 хүний материалыг тамгын газарт зохих журмын дагуу хадгалж байна.

Мөн захиргааны албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн 5 хүний хувийн ашиг сонирхолын урьдчилсан мэдүүлгийг “Авлигатай тэмцэх газар”-т хянуулахаар хүргүүлэн холбогдох зөвшөөрлийг авлаа.

Түүнчлэн “**Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан**”-г шинэчилсэн програмын дагуу гаргаж, Төрийн албаны зөвлөлд хугацаанд нь хүргүүлжээ.

Тамгын газрын дэргэдэх Захиргааны зөвлөл **6** удаа хуралдаж, Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн нийт **20** гаруй асуудлыг хэлэлцэн шийдвэрлэжээ.

Тамгын газрын дарга хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн нийт **138** тушаал гаргасан байна.

Одоо тамгын газрын харъяа албадын ажлын талаар товч дурдья.

1. Ерөнхий шүүгчийн ажлын алба.

Тус алба нь тайлангийн хугацаанд **31** албан бичиг, **124** өргөдөл, гомдол, хүлээн авч, хуулийн хугацаанд нь хариу өгсөн бөгөөд одоо **1** албан бичиг, **3** өргөдөл гомдлын үлдэгдэлтэй байна.

Ерөнхий шүүгчид гаргасан гомдлыг үндэслэн Ерөнхий шүүгчийн ажлын алба эрүүгийн **84**, иргэний **168**, захиргааны **57**, нийт **309** хэрэг хүлээн авч үүнээс эрүүгийн **81**, иргэний **160**, захиргааны **51** бүгд **641** хавтас, **129774** хуудас **292** хэргийн Ерөнхий шүүгчид танилцуулснаас

Ерөнхий шүүгч эрүүгийн 1, иргэний 1 хэрэгт буюу Эрүүгийн хуулийн 96 дугаар зүйлийн 96.1-д зааснаар ял шийтгүүлсэн Р.Эрдэнэ-Очирт холбогдох эрүүгийн хэрэг, С.Эрдэнэбаярын нэхэмжлэлтэй, “Аргайбэйт” ХХК-д холбогдох иргэний хэргийн тогтоолд хууль зөрчсөн үндэслэлээр дүгнэлт бичин Нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд Ерөнхий шүүгчийн дүгнэлтийг хүлээн авсан байна.

Харин дүгнэлт бичигдээгүй **290** хэрэгт гомдол гаргасан **341** иргэн, албан тушаалтанд зохих хариуг өгсөн байна. Албан бичгээр өгсөн хариуг үл зөвшөөрч дахин гаргасан **14** гомдлыг Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2012 оны 57-р захирамжид батлагдсан “Улсын Дээд шүүхийн хэрэг болон иргэд болон хуулийн этгээд, хэргийн оролцогчдоос гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах, хуваарилах, шийдвэрлэх журам”-ын 12.2-т зааснаар Ерөнхий шүүгчид дахин танилцуулж, улмаар Тамгын газрын дарга судлан хариу өгч, гомдол материалыг буцаасан байна. Өмнөх онтой харьцуулахад эрүүгийн хэрэг **11**-ээр өсч, иргэний хэрэг **32**-оор, захиргааны хэрэг **9**-өөр тус тус буурсан байна.

Ажлын албаны дарга, бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан ахлах зааварлагчийг байлцуулан хэргийн оролцогчид болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөгч **236** хүнийг сар бүрийн **4** дүгээр **7** хоногийн **пүрэв** гарагт болон хөдөө орон нутгаас ирсэн иргэдийг тухайн өдөрт нь хүлээн авч уулзан санал хүсэлтийг нь сонсож, тэдний санал, хүсэлтийг Ерөнхий шүүгчид тухай бүрт нь танилцуулж, зохих хариуг өгчээ.

Ерөнхий шүүгчид хандаж гаргасан гомдлын дагуу эрүү, иргэн, захиргааны хэргийг хянах явцад шүүх, шүүгчдийн болон захиргааны ажилтнуудын гаргасан алдаа, зөрчилд анхаарах асуудлаар тусгайлан бүртгэл хөтөлж, давхардсан тоогоор **19** шүүгч, **56** ажилтанд энэ талаар мэдэгдэж, зөвлөмж өгч ажиллажээ.

Түүнчлэн Ерөнхий шүүгч **Хөвсгөл, Өмнөговь, Дундговь, Завхан, Говь-Алтай** аймгийн шүүхийн шүүгч, ажилтнуудтай уулзалт ярилцлага зохион байгуулж, Улсын Дээд шүүх, Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс шүүн таслах ажиллагаа болон шүүхийн захиргааны удирдлагын талаар баримталж буй бодлого, чиглэлийг танилцуулж харилцан санал солилцсон байна.

Цагаатгалын үнэмлэх олгох талаар хэлмэгдэгчдийн төрөл садан болон Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссуудаар дамжуулан **47** өргөдөл, хүсэлтийг хүлээн авч “**Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хууль**”-д заасны дагуу Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2006 оны 11 дүгээр захирамж, 2012 оны 60 дугаар захирамжийг баримтлан нийтдээ **41** ширхэг үнэмлэх олгосноос **33** үнэмлэхийг /**16998-17030** хүртэлх дугаартай/ хүсэлт гаргагч нарт шинээр олгож, хаяж, үрэгдүүлсэн **8** үнэмлэхийг нөхөн бичиж өгсөн байна.

2. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба.

Тус алба нь шүүхийн шүүн таслах болон бусад үйл ажиллагааны талаар давхардсан тоогоор өдөр тутмын сонинд **414**, телевизэд **305**, радиод **82**, вэб сайтуудад **615** мэдээ, мэдээлэл бэлтгэн нийтлүүлж, нэвтрүүлжээ. Мөн телевизүүдийн урсдаг мэдээгээр давхардсан тоогоор **172** мэдээг олон нийтэд хүргэсэн байна. Үүний заримаас дурьдвал:

Телевизийн нэвтрүүлгийн хувьд:

1. Шүүхийн багц хуулиудын тухай;
2. “Шүүхийн захиргааны тухай хууль”-ийн тухай;
3. “Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийн тухай;
4. “Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль”-ийн талаар;
5. “Шүүхийн тухай хууль”-ийн талаар;
6. “Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийн талаар тус тус нэвтрүүлэг бэлтгэж, олон нийтэд хүргэжээ.

Түүнчлэн Шүүхийн тухай багц хуулиудын талаар Монголын Үндэсний олон нийтийн телевиз, TV 5, MN-25, MNC, Шууд, Eagle, Оллоо телевизүүдээр **30-90** минутын хугацаатай нэвтрүүлгийг бэлтгэн хүргүүлж, нэвтрүүлсэн байна.

Тус алба нь Монголын Үндэсний олон нийтийн телевизтэй хамтран “**Эрх зүйн хөтөч**” телесэтгүүлийг **3** дахь жилдээ амжилттай бэлтгэн явууллаа. Тухайлбал,

- Анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шүүгч нарын **20** теле ярилцлага;
- Эрүү, иргэн, захиргааны эрх зүйн сэдвээр давхардсан тоогоор **25** жүжигчилсэн телезохиомжийг тус тус бэлтгэжээ.

Радиоогийн нэвтрүүлгийн хувьд:

- “Иргэний болон захиргааны эрх зүйн маргааны шалтгаан, нөхцөл, анхаарах зарим асуудлууд” сэдэвт тогтмол нэвтрүүлэг;

- Шүүхийн тухай багц хуулиуд болон шүүхийн шинэчлэлийн талаар Улсын Дээд шүүхийн болон бусад шүүхийн шүүгч, захиргааны ажилтнуудын ярилцлагыг “Соёмбо” нэвтрүүлгээр тус тус олон нийтэд хүргэсэн байна.

Сонин, сайтын нийтлэлийн хувьд:

- Шүүхийн үйл ажиллагаа, Шүүхийн тухай багц хууль, шүүхээр шийдвэрлэсэн зарим төрлийн гэмт хэрэг, цаг үеийн асуудалтай холбоотойгоор шүүгч, шүүхийн ажилтан **30** хүний ярилцлага;
- Тодорхой хэрэг маргаан, түүнийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр болон шүүхийн шинэчлэлтэй холбоотой **32** нийтлэл, өгүүллэг;
- **2012** оны **1, 2, 3** дугаар улирлын шүүн таслах ажиллагааны мэдээ зэргийг тус тус өдөр тутмын болон бусад сонин, вэб сайтад нийтлүүлсэн байна.

Хэвлэлийн бага хурлын хувьд:

- “Монголын шүүхэд хэрэгжиж байгаа шүүхийн мониторингийн ач холбогдол, хэрэгжилт, цаашдын зорилт” сэдвээр
- “Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн үйл ажиллагаа, хянан шийдвэрлэсэн хэргийн тоо, маргааны төрлүүд, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал” сэдвээр
- “Шүүхийн цахим сан”-ийн талаар тус тус хэвлэлийн бага хурал зохион байгуулжээ.

Түүнчлэн хууль эрх зүйн чиглэлээр дагнан мэргэшиж буй сэтгүүлчдэд зориулан “**Шүүхийг сурвалжлах нь**” сэдэвт цуврал сургалтыг **хоёр** удаа зохиосон байна. Мөн анхан, давж заалдах шатны болон дагнасан шүүхүүдээс **2** сар тутмын мэдээг 4 удаа хүлээн авч, Ерөнхий шүүгчид танилцуулан, нэгтгэж, зарим мэдээллийг сайтууд болон телевизийн урсдаг мэдээгээр олон нийтэд дамжуулсан байна.

Улсын Дээд шүүхэд давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргаж ирүүлсэн эрүү, иргэн, захиргааны хэргийн талаар эрүүгийн **334**, иргэний **481**, захиргааны **428** оролцогчдод утсаар болон биечлэн лавлагаа өгч, эрх зүйн мэдээллээр ханган ажиллажээ.

3. Шүүхийн судалгааны төв.

Судалгааны төв нь шүүн таслах ажиллагааны чанар, үр нөлөөг дээшлүүлэх, хуулийг нэг мөр ойлгон, зөв хэрэглэж буй талаар дүгнэлт гаргах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга замыг тодорхойлох зэрэг судалгаа хийх, төсөл боловсруулах зэрэгт түлхүү анхааран ажиллажээ.

“**Дээд шүүхийн мэдээлэл**”, “**Монголын төр, эрх зүй**”, сэтгүүлийг эрхлэн гаргаж, олон нийтийн хүртээл болгож байна. Мөн зарим албатай хамтран “Монгол Улсын шүүхийн 2011 оны жилийн тайлан”-г эмхтгэн хэвлүүлэхээр Тамгын газарт төслийг бэлтгэн өгчээ.

Тус төв тоон болон чанарын **34** судалгаа хийснээс чанарын судалгаа **4** буюу **11,7** хувийг эзэлж байна.

Ерөнхий шүүгчид-**2**, Эрүүгийн хэргийн танхимд-**3**, Иргэний хэргийн танхимд-**5**, Захиргааны хэргийн танхимд-**2**, Хэвлэл мэдээллийн албанд-**8** нийт тоон болон чанарын **20** судалгааг хийж гүйцэтгэжээ.

Түүнчлэн Шүүхийн багц хуулийн ажлын хэсэгтэй хамтран уг хуулиудын шинэчилсэн найруулгад, Эрүүгийн хэргийн танхимтай хамтран “Эрүүгийн хууль”, “Эрүүгийн байцаан шийтгэх хууль”-ийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд **9** санал өгч ажиллажээ.

Шүүн таслах ажиллагааны статистик, тоон мэдээллийг 2012 оны эхний улиралуудын болон хагас, бүтэн жилийн мэдээг нэгтгэн гаргаж, хянан холбогдох албан тушаалтан, байгууллагуудад хүргэх ажлыг зохион байгуулсан байна.

Түүнчлэн шүүхийн нэгдсэн санг бүрдүүлэх, баяжуулах, хяналт тавих ажлыг холбогдох журмын дагуу гүйцэтгэжээ. Тухайлбал:

- Ерөнхийлөгчийн зарлиг **36**;
- Шинээр батлагдсан хууль **244**, нэмэлт, өөрчлөлт орсон хууль **151**, хүчингүй болсон хууль **29** ;
- Улсын Их Хурлын шинээр баталсан тогтоол **118**, өөрчлөлт оруулсан **9**, хүчингүй болсон тогтоол **1**-ийн тус тус шүүхийн мэдээллийн нэгдсэн санд оруулжээ.

Холбогдох судалгаа, статистик мэдээ, мэдээлэл, баримтын талаар шүүхийн ажилтан болон зарим хуульч нийт **127** хүнд лавлагаа, **36** байгууллага, аж ахуйн нэгжид шүүхийн статистик мэдээний тоон мэдээллийг тус тус өгсөн байна.

Түүнчлэн “Монгол Улсын ялын бодлого (50 жилээр)”, “Цагдаагийн байгууллагын ажилтнуудын ёс зүйн байдал, үйл ажиллагааны орчин” зэрэг цогц судалгаан дээр ажиллаж байна.

Мөн Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран “Монголын криминологи” сурах бичгийг хамтран бичиж хэвлэлтэнд шилжүүлэхэд бэлэн болгосны зэрэгцээ захирал Ч.Нямсүрэн олон улсын болон хуулийн байгууллагуудаас зохион байгуулсан эрдэм шинжилгээний бага хуралд 4 илтгэл тавьж хэлэлцүүлж, гадаад дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүл, эмхтгэлд 4 өгүүлэл бичиж хэвлүүлжээ.

4. Санхүү, хангамж, үйлчилгээний алба.

Улсын Дээд шүүх 2012 онд урсгал зардалд 1 тэрбум 606 сая төгрөг, улсын төсвөөр санхүүжигдэх хөрөнгө оруулалтад 193 сая төгрөг, нийт 1 тэрбум 799 сая төгрөгийн төсөв батлагдаж, батлагдсан төсвийг зардлын ангилал тус бүрээр зохих журмын дагуу зарцуулж, санхүүгийн мэдээ, тайланг холбогдох байгууллагуудад цаг хугацаанд нь гарган өгч, ямар нэгэн байгууллага, хувь хүмүүст өр авлага гаргалгүй ажиллажээ.

Шүүгч, ажилтан, ахмадын зөвлөлийн гишүүн 10 хүнд 4,8 сая төгрөгийн буцалтгүй тусламж, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн, дурсгалын зүйлс 1 хүнд 149 мянган төгрөг нийт 4.9 сая төгрөгийг тус тус олгожээ.

2012 оны ээлжийн амралтаар өөрийн буюу эхнэр, нөхрийн төрсөн нутагт очиж амарсан 5 шүүгч, ажилтанд унааны зардалд 209 мянган төгрөгийг тооцон олгосон байна.

Түүнчлэн 2012 онд үр бүтээл, санаачлага, идэвх, зүтгэл гарган ажилласан тус шүүхийн шүүгч, ажилтнууд, ахмадын зөвлөлийн гишүүд болон бусад байгууллагын ажилтан нийт давхардсан тоогоор 118 хүнийг 44,2 сая төгрөгөөр шагнаж урамшууллаа.

Мөн албан ажлын шаардлагаар шүүгч, ажилтнуудад зайлшгүй шаардлагатай байгаа автомашин “HUNDAI COUNTY” маркийн дунд оврын автобус 88 сая төгрөгөөр худалдан авч үйлчилгээнд ажишлаж байгаа бөгөөд хяналт, хамгаалалтын тоног төхөөрөмжийг 78,8 сая төгрөгөөр худалдан авч байрлуулан ашиглаж байна. Мөн барилгын дээврийн засварын ажлыг 19,9 сая төгрөгөөр засварлалаа.

Төрийн өмчийн хорооны 2012 оны 02 сарын 16-ны №46 тоот тогтоолыг үндэслэн Улсын Дээд шүүхийн Тамгын газрын даргын 2012 оны 04 дүгээр сарын 12-ны №42 тоот тушаалаар 2012 оны 04 дүгээр сарын 12-ны өдрөөс 2012 оны 05 дугаар сарын 30-ны өдөр хүртэл Төрийн өмчийн тооллогын ажлыг зохион байгуулах коммисыг 7 ажилтны бүрэлдхүүнтэй байгуулж ажиллан хугацаандаа багтаан тооллого хийж Төрийн өмчийн хороонд хугацаанд нь тайланг гарган хүргүүлжээ.

Улсын Дээд шүүхийн Тамгын газрын даргын 2012 оны 11 сарын 27-ны өдрийн 120 тоот тушаалаар 2012 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг хийв.

Тооллогоор :

- 372,8 сая төгрөгийн конторын барилга;
- 119,6 сая төгрөгийн орон сууц 2 орон сууц;
- 670.7 сая төгрөгийн 12 автомашин;
- 182,8 сая төгрөгийн инженерийн шугам;
- 8.3 сая төгрөгийн санхүү, бичиг хэрэг, вэб сайтын программ хангамж;
- 2,0 сая төгрөгийн номын фонд;
- 469.4 сая төгрөгийн тавилга эд хогшил;
- 114.0 сая төгрөгийн бараа, материал нийт 1 тэрбум, 939.6 сая төгрөгийн эд хөрөнгө тоологджээ.

Тооллогын дүнд дутсан, алга болж үрэгдсэн хөрөнгө гараагүй болно.

2013 оны төсөвт урсгал зардалд 2 тэрбум 165 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 5 тэрбум 792 сая төгрөг, нийт 7 тэрбум 957 сая төгрөг батлагдаж, 2012 оныхтай харьцуулахад нийт төсөв 4,4 дахин буюу 6 тэрбум 158 сая төгрөгөөр нэмэгдлээ.

5. Дотоод ажил, зохион байгуулалт, хяналтын алба.

Тайлангийн хугацаанд тус алба нь нийт 311 өргөдөл гомдол, 498 албан бичиг, 2105 хавтаст хэрэг хүлээн авч, зохих журмын дагуу бүртгэн, бүртгэл хяналтын карт нээж, уг албан бичгүүдийг Ерөнхий шүүгчид танилцуулсны дагуу шүүгч, ажилтнуудад хувиарлан өгч шийдвэрлүүлсэнээс гадна 3079 албан бичигт дугаар өгч холбогдох шүүх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад явуулжээ. Өмнөх онтой харьцуулахад хүлээн авсан өргөдөл гомдол 81-ээр, албан бичиг 77-оор, явуулсан бичиг 346-аар тус тус буурчээ.

Мөн хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Шүүгчийн туслах-шинжээч **Ө.Уянга** Төв аймаг дахь сум дундын шүүхийн, Шүүгчийн туслах-шинжээч **Г.Билгүүн** Нийслэлийн Багануур дүүргийн шүүхийн, Шүүгчийн туслах-шинжээч **Д.Алтанжигүүр** Орхон аймаг дахь сум дундын шүүхийн, Бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан ахлах мэргэжилтэн **Ч.Даваасүрэн**

Хөвсгөл аймаг дахь сум дундын шүүхийн, Шүүгчийн туслах-шинжээч **Н.Дамдинсүрэн** Говьсүмбэр аймгийн Захиргааны хэргийн шүүхийн, Шүүгчийн туслах-шинжээч **Н.Гэрэлтуяа** Увс аймаг дахь сум дундын шүүхийн, Тамгын газрын даргын туслах-шинжээч **Ш.Гандансүрэн** Өвөрхангай аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн, Цагаатгалын асуудал хариуцсан шинжээч **Л.Одончимэг** Дундговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилогдож, **Э.Амин-Эрдэнийг** Эрүүгийн хэргийн танхимын тэргүүний туслах-ахлах шинжээчийн, **М.Баясгаланг** Иргэний хэргийн танхимын тэргүүний туслах-ахлах шинжээчийн, **О.Батсүхийг** Захиргааны хэргийн танхимын тэргүүний туслах-ахлах шинжээчийн албан тушаалд томилон дэвшүүлэн ажиллуулж байна.

Түүнчлэн **Д.Отгонбаатарыг** Дотоод ажил, зохион байгуулалтын асуудал хариуцсан шинжээчийн, **Б.Бямбабаатарыг** Тамгын газрын даргын туслах-шинжээчийн, **Н.Нямдаваа**, **Ц.Амаргэрэл**, **Ж.Сэмжид**, **Б.Дүүрэнжаргал** нарыг Шүүгчийн туслах-шинжээчийн, **Ч.Баярсүрэнг** Эрүүгийн хэргийн шүүн таслах ажиллагааны судалгаа хариуцсан шинжээчийн, **С.Бурмааг** Бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан ахлах мэргэжилтэний, **Ц.Сансармааг** Хууль тогтоомжийн системчлэлийн ажил эрхэлсэн ахлах мэргэжилтэний, **Т.Майцэцэгийг** Мэдээлэл, лавлагааны ажил хариуцсан мэргэжилтэний албан тушаалд, **Ш.Пүрэвхандыг** Няравын, **Д.Пүрэвдагва**, **Б.Төгөлдөр** нарыг жолоочийн, **Г.Баясгаланг** мужааны ажилд Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн Тамгын газрын даргын тушаалаар тус тус томилон ажиллуулж байна.

Тайлангийн хугацаанд:

- Шүүгч **Л.Атарцэцэг**, **Ч.Тунгалаг** нарын төрийн албан хаасан хугацааны, шүүгч **Т.Уранцэцэгийн** докторын зэргийн нэмэгдлийг,
- Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга **Р.Ганпүрэв**, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны дарга **Н.Долгорсүрэн**, Компьютерийн программ хангамжийн асуудал хариуцсан референт **Э.Баярбаатарт** шүүгчийн туслах- шинжээч **Н.Гэрэлтуяа**, Бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан ахлах мэргэжилтэн **Ч.Даваасүрэн**, шинжээч **Ш.Даваадулам**, шинжээч **Д.Оюунчимэг**, нарын **6** хүний **зэрэг дэвийг**;
- Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга **Р.Ганпүрэв**, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны дарга **Н.Долгорсүрэн**, Ерөнхий шүүгчийн туслах **С.Батгэрэл**, Компьютерийн программ хангамжийн асуудал хариуцсан ахлах шинжээч **С.Сундуйжав**, Тамгын газрын даргын туслах-шинжээч **Ш.Гандансүрэн**, Шүүгчийн туслах-шинжээч **М.Мөнхтөр**, **Г.Билгүүн**, **Х.Идэр**, **Г.Солонго**, **М.Баясгалан**, **М.Далайхүү**, шинжээч **Ш.Даваадулам** нарын төрийн алба хаасан хугацааны зэргийн **нэмэгдлийг** тус тус шинээр болон нэмэгдүүлэн олгожээ.

“**Билгийн тооллын хаврын тэргүүн сар - Цагаан сарын баяр**”, “**Хүүхдийн баяр**”, “**Ахмадын баярын өдөр**” зэрэг тэмдэглэлт баяруудыг тохиолдуулсан арга хэмжээг тухай бүр зохион байгуулж, ойн баяр болон тэмдэглэлт өдрүүдэд Улсын Дээд шүүх дээр сахилга, хариуцлага, дэг журам, сонор сэрэмжийг өндөржүүлэх зорилгоор **6** удаагийн тушаалаар **11** ажилтныг хариуцлагатай эргүүлээр томилон ажиллууллаа.

Тайлангийн хугацаанд **7** ажилтан төрийн өөр ажил, албан тушаалд дэвшин ажиллах болсон, өндөр насны тэтгэвэрт гарсан, өөрөө хүсэлт гаргасан зэрэг шалтгааны улмаас төрийн албанаас **2** чөлөөлөгдөж, **1** ажилтанд хүүхэд асрах чөлөөг тус тус олгожээ.

Шүүгч, ажилтнуудын гэр бүлээс их, дээд сургуульд 2011-2012 оны хичээлийн жилд суралцаж байгаа нийт **5** оюутны “Сургалтын төлбөрийг төрөөс хариуцан санхүүжүүлэх тухай” гэрээг Сургалтын төрийн сантай байгуулж, төлбөрийг нь төлжээ.

Монгол Улсад шүүх байгуулагдсаны 101 жил, Улсын Дээд шүүх үүсэн байгуулагдсаны 85 жилийн ойг тохиолдуулан “**Шүүхийн спортын их наадам-2012**” спортын 10 төрөлт тэмцээнийг зохион байгуулж, түүнд давхардсан тоогоор **102** багийн **833** тамирчид оролцлоо. Мөн хуулийн төв байгууллагуудын дунд зохион байгуулагддаг “**Шилжин явах цом**”-ын төлөө спортын 5 төрөлт тэмцээнд Улсын Дээд шүүхийн баг тамирчид амжилттай оролцож, багийн нийлбэр дүнгээр **2** дугаар байрт шалгарлаа.

Дөрөв. Гадаад арга хэмжээний талаар

Шүүхийн гадаад харилцаа жилээс жилд өргөжиж, шүүгч, ажилтнууд гадаад сургалтад хамрагдах, дэлхийн болон олон улсын, тивийн, бүсийн чуулга уулзалт, эрдэм шинжилгээний бага хуралд оролцох, шүүн таслах ажиллагааны талаарх гадаад улсын туршлага судлах ажил нэмэгдэж байна. Тухайлбал,

- Шүүгч **Л.Бямбаа** тэргүүтэй төслийн багийн шүүгч, ажилтнууд 2012 оны 4 дүгээр сарын 23-29-ний өдрүүдэд ХБНГУ-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс хэрэгжүүлж буй “**Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчныг**

баталгаажуулах” төслийн хүрээнд ХБНГУ-д шүүхийн цахим сүлжээ, түүний ашиглалтын талаарх танилцах айлчлал;

- Ерөнхий шүүгч Ц.Зориг 2012 оны 5 дугаар сарын 3-8-ны өдрүүдэд Катар улсын Доха хотноо зохион байгуулагдсан **“Дэлхий дахинд хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх нь”** сэдэвт чуулга уулзалтад;
- Ерөнхий шүүгч Ц.Зориг, танхимын тэргүүн С.Нямжав, О.Зандраа, Тамгын газрын дарга Д.Эрдэнэчулуун, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны дарга Н.Долгорсүрэн нар 2012 оны 5 дугаар сарын 20-27-ны өдрүүдэд Ханнс-Зайделийн сангийн урилгаар ХБНГУ-д ажлын айлчлал;
- Шүүгч А.Доржготов тэргүүтэй зарим давж заалдах шатны Ерөнхий шүүгч, шүүгчид 2012 оны 9 дүгээр сарын 2-16-ны өдрүүдэд Тайваны “Шүүгчдийн давтан сургалтын төв”-өөс зохион байгуулсан **“Тайваны шүүхийн тогтолцоо, бүтэц зохион байгуулалт, харилцан туршлага солилцох нь”** сэдэвт 14 хоногийн сургалтад;
- Шүүгч Ч.Тунгалаг, Нийслэлийн шүүхийн шүүгч Л.Даваасүрэн нар Сингапур Улсын Дээд шүүхээс 2012 оны 10 дугаар сарын 2-5-ны өдрүүдэд зохион байгуулагдсан **“Иргэний болон эрүүгийн хэргийг шүүх хурлаар шийдвэрлэхээс бусад альтернатив аргуудыг хэрэглэх нь”** сэдэвт сургалтад;
- Танхимын тэргүүн О.Зандраа, шүүгч П.Цэцгээ нар 2012 оны 10 дугаар сарын 13-29-ний өдрүүдэд, шүүгч Д.Тунгалаг 2012 оны 11 дүгээр сарын 24-нөөс 12 дугаар сарын 09-ний өдрүүдэд АНУ-ын Флорида мужид шүүхийн практик судлах чиглэлээр сургалтад;
- Улсын Дээд шүүхийн шүүгч Ц.Сумъяа 2012 оны 12 дугаар сарын 5-12-ны өдрүүдэд БНЭУ-ын **Лакнау** хотноо зохион байгуулагдсан **“Дэлхийн Ерөнхий шүүгчдийн 13 дугаар бага хурал”**-д;
- Танхимын тэргүүн Б.Ундрах 2012 оны 12 дугаар сарын 11-15-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Киргиз Улсад зохион байгуулагдсан **“Шүүхийн бие даасан, хараат бус байдлыг хангах нь”** сэдэвт сургалт-танилцах айлчлалд тус тус оролцжээ.

Тав. Сургалт, семинарын талаар

2012 оны байдлаар Улсын Дээд шүүх дараах сургалт, семинарыг зохион байгуулж, оролцлоо. Үүнд:

- 2012 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр **“Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөрийг шүүхэд хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх үндсэн чиглэл”** болон шүүн таслах ажиллагаанд анхаарах зарим асуудлаар бүсчилсэн уулзалт-ярилцлага;
- 2012 оны 3 дугаар сарын 30, 5 дугаар сарын 04-ний өдрүүдэд Захиргааны хэргийн танхимын шүүгчид Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх, Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн шүүгчидтэй хууль хэрэглээний асуудлаар уулзалт, ярилцлага;
- 2012 оны 4 дүгээр сарын 26-27-ны өдрүүдэд Захиргааны хэргийн танхимын тэргүүн О.Зандраа Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Нээлттэй нийгэм Форумтай хамтран **“Их Тэнгэр”** цогцолборт **“Нийтийн эрх ашгийг шүүхэд нэхэмжлэн хамгаалах нь”** сэдэвт илтгэл хэлэлцүүлж;
- 2012 оны 5 дугаар сард шүүгч А.Доржготов **“Үнэт цаасны эрх зүй”, “Банк, үнэт цаас, санхүүгийн үйлчилгээ”** сэдэвт сургалтад;
- 2012 оны 5 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд шүүгч А.Доржготов, Д.Тунгалаг нар Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар зохион байгуулж явуулсан **“Эдийн засгийн олон улсын форум”**-д;
- 2012 оны 6 дугаар сард шүүгч А.Доржготов **“Эдийн засгийн эрх зүйн маргааныг шийдвэрлэж буй шүүхийн практик, анхаарах асуудал”** онол практикийн хуралд илтгэл хэлэлцүүлж;
- 2012 оны 09 дугаар сарын 26-29-ний өдрүүдэд сургагч багш Захиргааны хэргийн танхимын тэргүүн О.Зандраа, шүүгч Л.Атарцэцэг нар Төв, орон нутгийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгч, захиргааны ажилтнуудад **“Герман-Монголын захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн харьцуулалт”** сэдвээр бүсчилсэн сургалтыг;
- 2012 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр шүүгч Б.Бат-Эрдэнэ, Д.Эрдэнэбалсүрэн нар сэтгүүлчдэд зориулсан **“Шүүхийг сурвалжлах нь”** цуврал сургалтад **“Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа”, “Шинэ төрлийн гэмт хэрэг”** зэрэг сэдвүүдээр, мөн

шүүгч Б.Бат-Эрдэнэ зүүн бүсийн 3 аймаг, Нийслэл, дүүргийн шүүхийн шүүгч нарт Эрүү, Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй чиглэлээр хуульчдын багц цагийн кредит олгох сургалтад хичээл зааж;

- 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр шүүгч Ч.Тунгалаг Цагдаагийн байгууллагын зөвлөгөөнд **“Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд бодит үнэнийг тогтоох, мэтгэлцэх зарчмыг хуульчлан тусгасан нь”** сэдэвт илтгэл хэлэлцүүлж;
- 2012 оны 12 дугаар сарын 07-ны өдөр шүүгч Ц.Сумъяа, П.Цэцгээ нар Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч нарт **“Санал”, “дүгнэлт”, “мэдэгдэл”** зэрэг захиргааны байгууллагын шийдвэрийн талаарх ойлголт мөн **“Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.8 дахь хэсгийг хэрэглэх асуудлаарх шүүхийн практик”** сэдвээр 2 цагийн сургалтад хичээл зааж;
- 2012 оны 12 дугаар сарын 12-14-ний өдрүүдэд Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран тус шүүхийн шүүгч, ажилтнуудад зориулсан **“Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэх зарим асуудал”, “Үндсэн хуулийн дархлаа”, “Хуульчийн ёс зүй”, “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа- Шинэ хуулийн үзэл баримтлал”, “Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа-Шинэ хуулийн үзэл баримтлал”, “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа- Шинэ хуулийн үзэл баримтлал”** зэрэг сэдэвт хуульчдад кредит олгох сургалтуудыг тус тус зохион байгуулж болон тэдгээрт оролцож ажиллажээ.

Тайлангийн хугацаанд бусдаасаа илүү идэвх, зүтгэл, үр бүтээл гарган ажилласан шүүгч О.Зандраа, Ц.Амарсайхан, Б.Бат-Эрдэнэ, А.Доржготов, Ч.Тунгалаг, албаны дарга Н.Долгорсүрэн, референт А.Эрдэнэцэцэг, С.Батгэрэл, ахлах шинжээч Э.Амин-Эрдэнэ, О.Батсүх, шинжээч Х.Идэр, Ш.Даваадулам, Б.Дүүрэнжаргал, ахлах мэргэжилтэн Д.Оюунчимэг, Т.Майцэцэг, бичиг хүргэгч А.Пүрэвдулам, жолооч П.Пүрэвдагва, Б.Жумдаандорж, мужаан Г.Баясгалан, үйлчлэгч Ц.Цэцэгсүрэн, Ц.Пагам нарт хамт олныхоо нэрийн өмнөөс болон хувиасаа талархал илэрхийлж, ажилд нь амжилт хүсье.

Эрхэм шүүгч, ажилтнууд аа!

Улирч буй 2012 онд бид амжилт бүтээл арвин байлаа. Ирж буй 2013 он биднээс шүүхийн тухай багц хуулиудыг хэрэгжүүлэх, шүүхийн шинэчлэлийг шинэ шатанд гарган зохион байгуулах, шүүн таслах болон шүүхийн захиргааны удирдлагын шинэ бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хэрэгжүүлж ажиллах нэн хариуцлагатай, түүхэн үүргийг хүлээж байна. Тиймээс бид ирж буй жилд нөр их ажлыг амжилттайгаар гүйцэлдүүлэх шаардлагатай бөгөөд үүнд та бүхнийг идэвхи санаачлага, итгэл зүтгэл, үр бүтээл гарган ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Та бүхэндээ шинэ жилийн баярын мэнд дэвшүүлж, аз жаргал, эрүүл энхийг хүсэн ерөөе.